



МОНГОЛ УЛС
ХОВД АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2019 оны 01 сарын 28 өдөр

Дугаар 1/65

Ховд

Газар эзэмших эрх шилжүүлэх тухай


Монгол улсын Газрын тухай хуулийн 38 дугаар зүйлийн 38.1, 38.3, 38.4 дэх заалт аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2010 оны 12 дугаар сарын 24-ний өдрийн 267 дугаар тогтоолыг тус тус үндэслэн **ЗАХИРАМЖЛАХ** нь:

1. Жаргалант сумын Магсаржав багийн нутаг дэвсгэр Ш.Эрэнцэнгийн 2 дугаар гудамж 201 а тоотод байрлах худалдаа, үйлчилгээний зориулалттай "Оюумандал" ХХК-ний /2033011/ 700 метр квадрат газрыг, газар эзэмших эрх шилжүүлэх гэрээний дагуу Лхагвын Баясгаланд /УВ85011612/ худалдаа үйлчилгээний зориулалтаар 13 жилийн хугацаагаар,
2. Жаргалант сумын Жаргалан багийн нутаг дэвсгэр 2-80 айлын зүүн урд талд байрлах авто гражны зориулалттай Давхарсүрэнгийн Батчулууны /П380100312/ 20 метр квадрат газрыг, газар эзэмших эрх шилжүүлэх гэрээний дагуу Шүрхүүгийн Зоригод /ПП88012211/ мэдээллийн сангийн зургийн дагуу 31 метр квадрат болгон авто гражны зориулалтаар 10 жилийн хугацаагаар,
3. Жаргалант сумын Алагтолгой багийн 1 дүгээр гудамжны 18 тоотод байрлах гэр бүлийн хэрэгцээний зориулалттай Чойжинжавын Дашдэлэг /ПЭ64041013/ 310 метр квадрат газрыг, газар эзэмших эрх шилжүүлэх гэрээний дагуу Уранчимэгийн Ангирмаад /ПД96082408/ мэдээллийн сангийн зургийн дагуу 371 метр квадрат, Баянбулаг 1 дүгээр гудамжны 117 тоот болгон гэр бүлийн зориулалтаар 3 жилийн хугацаагаар тус тус эзэмшүүлсүгэй.
4. Газар эзэмших эрхийг хуулийн дагуу шилжүүлж газраа зориулалтын дагуу үр ашигтай, зүй зохистой эзэмшиж, хамгаалж, газар эзэмшүүлэх гэрээнд заасан

нөхцөл болзлыг биелүүлж ажиллахыг дээрх иргэн, аж ахуйн нэгжүүдэд үүрэг болгосугай.

5. Газар эзэмших эрх нь баталгаажсан иргэн, аж ахуйн нэгж байгууллагатай газар эзэмшүүлэх гэрээ байгуулж, газар эзэмших эрхийн гэрчилгээ олгон, газрын төлбөрийг хууль тогтоомжийн дагуу төвлөрүүлэн гэрээний биелэлтэнд хяналт тавьж ажиллахыг Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газар /Б.Баярсүх/-т даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



Б.ДҮГЭРЖАВ

